

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2024/75/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 70483413 Цахим хаяг: Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn “Цэгц төв богд аудит” ХХК-ийн Ахлах аудитор Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13; Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.19

№

36

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 1007 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний болон нэг иргэнд ногдох санхүүжилт 329,727.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардлын санхүүжилт 15,800.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамнаас өр төлөхөд зориулж 50,000.0 мянган төгрөг, шинээр барилга байгууламж ашиглалтад орж 2,104,209.0 мянган төгрөг орлого авсан, хандив тусламжаар 39,492.6 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй орлого авчээ.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 хөтөлбөр, 43 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 12 арга хэмжээг 100.0 хувь, 13 арга хэмжээг 90.0-97.0 хувь, 14 арга хэмжээг 60.0-90.0 хувь, 4 арга хэмжээг 50.0 хувиар биелэлтийг хүргүүлжээ. Сумын Засаг даргын гэрээний биелэлтийн үнэлгээ гараагүй байна. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээгээр 72.74 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	82,859.6	98,750.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	397,428.3	2,512,085.5
	Нийт хөрөнгийн дүн	480,287.9	2,610,835.8
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	480,287.9	2,610,835.8
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	480,287.9	2,610,835.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	786,168.7	2,539,229.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	362,442.5	408,656.4
	Үйл ажиллагааны үр дүн	423,746.2	2,130,572.9
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	25.0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	423,746.2	2,130,547.9
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	414,164.7	480,287.9
	Тайлант оны үр дүн	66,123.2	2,130,547.9
	Эцсийн үлдэгдэл	480,287.9	2,610,835.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	381,869.4	390,075.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	366,456.9	363,461.1
	Үйл ажиллагааны ЦМГ	15,412.5	26,614.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(15,077.0)	(20,260.7)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	335.4	6,353.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	335.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	335.4	6,688.7
Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		367,921.8
	Урсгал зардал		367,921.8
	Хөрөнгийн зардал		-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		374,275.1
	Эрүүл мэндийн даатгалын сангаас		324,275.1
	Туслах үйл ажиллагааны орлогоос		50,000.0
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	335.4	6,688.7
Төсвийн гүйцэтгэлийн тайлан ОН			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		15,770.3
	Урсгал зардал		15,770.3
	Хөрөнгийн зардал		-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		15,770.3
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		15,770.3

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар илэрсэн нийт 3.1 төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт

1. Хоёр ажилтанд амралт цалин давхардуулан 0.6 сая төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.5.2. батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; 16.5.3. батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох; 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоолоо.

2. Цалингийн хүснэгтээр 8-р сард 0.3 сая төгрөг илүү олгоод дараа сард суутгаагүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1 дэхь заалт/ Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно/, Төрийн албаны тухай хуулийн 57.1-т /Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно./ заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоолоо.

3. Улирлын үр дүнгийн урамшуулал 2.2 төгрөг дутуу олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана"-ын зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Дутуу олгосон урамшууллыг нөхөн олгох төлбөрийн акт тогтоолоо.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төв	3	3.1	3	3.1	-	-	-	-	-	-	-	-
Дүн	3	3.1	3	3.1						-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал



Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төв	1				1			
Дүн	-	-	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлт гүй	Хязгаарл алттай	Сөрөг	Дүгнэлт егехөөс тагалзса
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулс ан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			